

2.2. Яам, агентлагуудаас ирүүлсэн саналын шинжилгээ

“Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2045 он”-ын төсөлд Гадаад харилцааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Эрчим хүчний яам, Барилга хот байгуулалтын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яам, Батлан хамгаалахын яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам зэрэг нийт 13 яамнаас ирсэн бодлогын саналаас 11 яам нь байршил тусгагдсан харин Эрүүл мэндийн яам, Сангийн яамны санал нь огт байршил тусгагдаагүй байна. Байршил тусгагдсан саналуудыг салбар тус бүрээр орон зайд зураглав.

Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэн саналын шинжилгээ

Барилга, хот байгуулалтын салбарын саналаа урт хугацааны хөгжлийн бодлогыг хангах үндсэн зорилго бүхий бодлого, түүний зорилт, арга хэмжээнүүдийг дараах дэд салбаруудаар тодорхойлсон байна.

- Газрын харилцаа, геодези, зураг зүйн дэд салбар 1 зорилго, 5 зорилт;
- Хот байгуулалтын дэд салбар 1 зорилго, 3 зорилт;
- Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн дэд салбар 2 зорилго, 4 зорилт;
- Орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн дэд салбар 1 зорилго, 3 зорилтууд бүхий санал ирүүлсэн байна.

Дээрх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжилтийн хувьд 4 түвшинд боловсруулан ирүүлсэн байна. Үүнд 2020-2025 он, 2026-2030 он, 2031-2035 он, 2036-2040 он, 2041-2045 онуудын түвшин тус бүрт шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, нийгэм, эдийн засгийн урьдчилсан нөлөөлөл зэргийг тооцсон байна.

Өнгөрсөн 25 жилийн хугацаанд тус салбарт Улсын барилгын хороо, Барилгын яам, Барилга, хот байгуулалтын комисс, Дэд бүтцийн хөгжлийн яам, Дэд бүтцийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам болон өнөөгийн Барилга, хот байгуулалтын яам гэсэн бүтцээр төрийн захиргааны төв байгууллага ажиллаж, барилга, хот байгуулалтын салбарын бодлогыг зах зээлийн харилцаанд нийцүүлэн төлөвлөн хөгжүүлж иржээ.

Барилга, хот байгуулалтын салбар ирээдүйн 25 жилийн салбарын урт хугацааны бодлогыг үндсэн 5 зорилго дэвшүүлэн тодорхойлсон байна. Үүнд:

Зорилго 1. Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ;

Зорилго 2. Байгаль, нийгэм, эдийн засгийн хөгжлийн зүй тогтлын дагуу хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутаг, хот суурин газрын нэгдсэн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлнэ;

Зорилго 3. Хууль, эрх зүйн орчин, норм, нормативыг боловсронгуй болгох замаар салбарын хөгжлийг эрчимжүүлнэ;

Зорилго 4. Эх орны эрдэс баялгийн нөөцийг зохистой ашиглах замаар импортыг орлох, экспортын баримжаатай барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлнэ;

Зорилго 5. Орон сууц, нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн хангамж, чанар үйлчилгээг нэмэгдүүлэх замаар иргэдийн тав тухтай амьдрах орчин нөхцөлийг сайжруулна; гэсэн зорилгууд дэвшүүлж түүнд хамаарах зорилтууд тавьсан байна.

Дээрх зорилгуудаас хот байгуулалтын салбарт чухал нөлөө бүхий бодлого арга хэмжээг тодруулан авч үзвэл:

Салбарын хөгжлийн философи, үнэт зүйл:

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, байгаль орчин нийгэм, эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлагад тулгуурлан хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орчныг бүрдүүлж, хот байгуулалтын тогтвортой хөгжлийг хангана.

Салбарын эрхэм зорилго:

Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн хөгжлийн оновчтой тогтолцоонд тулгуурлан хот, тосгоныг төлөвлөх, барьж байгуулахад оршино.

Салбарын зорилтууд:

- "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

- Бүс нутгийн хөгжлийн үндсэн чиглэл, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо, түүх, соёлын уламжлал, хот, хөдөөгийн хүн амд үйлчлэх хүрээ зэргийг харгалзан хот, тосгоны оновчтой тогтолцоог тодорхойлж, хөгжүүлэх;

- Улс, орон нутгийн зэрэглэлтэй хотуудын хөгжлийг дэмжсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

- Улаанбаатарын болон бусад бүсийн хэмжээнд Улаанбаатар хотын хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний бөөгнөрлийг задлах, дагуул, хаяа хотуудыг хөгжүүлж, хотоос орон нутагт үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэхийг дэмжих, нийслэл хотын хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;

Салбарын хөгжлийг хангах зарчим:

Хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагаанд баримтлах зарчим дараах зарчмыг баримтална:

- Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хангах;

- хүн амын эрүүл, аюулгүй байдал, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах;

- хот байгуулалтын үйл ажиллагаанд нийтийн эрх ашгийг эрхэмлэх, олон нийтийн оролцоо, оролцогч этгээд болон хөгжлийн бэрхшээлтэй хүний тэгш эрхийг хангах, ил тод, нээлттэй, төрийн болон олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх;

- хот төлөвлөлт, хот байгуулалтын үйл ажиллагааны залгамж чанар, уялдаа холбоог хангах.

Засгийн газрын 2016 оны 249-р тогтоолын хавсралт “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 1-р хавсралтын хүснэгтийн дагуу “Хот байгуулалт, газар зохион байгуулалтын дэд салбар”-г хамаарагдах саналуудыг салбарын ерөнхий баримтлах бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлал, зарчим, зорилтод уялдаж байгаа эсэхээр дүн шинжилгээ хийв.

№	БХБЯ-ны зорилт	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	Үнэлгээ	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Үнэлгээ	Олон улсын тогтвортой хөгжлийн зорилго-2030	Үнэлгээ
1	Монгол орны нутаг дэвсгэрийн 55%-ийг 1:25000 масштабтай байр зүйн тоон зургаар зурагжуулах	Зорилт. 4.7.5.г	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5; Зорилт 6;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
2	Сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээний зураглал (“Хот байгуулалтын мэдээллийн сан”-гийн суурь өгөгдлийг бүрдүүлэх)	Зорилт. 4.7.5.г	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 6; Зорилт 7;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
3	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээ ажиллуулах	Зорилт. 4.7.5.е.	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
4	”Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”	Зорилт. 4.7.5. 4.7.5.а	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
5	”Бүс нутаг, хот төлөвлөлтийн институт” төүг-ыг байгуулах	Зорилт. 4.7.5.е.	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5;	Агуулгын хувьд уялдсан	~	Огт хамааралгүй
6	”Бүсийн хөгжлийн төсөл” боловсруулах	Зорилт. 4.7.5.а. 4.7.5.б.	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
7	Орхон, дархан-уул аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Зорилт. 4.7.5.б. 4.7.5.в. 4.7.1.е	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5.	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
8	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн зураг төсөл боловсруулах	Зорилт. 4.7.5.б. 4.7.5.в.	Агуулгын хувьд уялдсан	2.1.5 дахь хэсгийн Зорилт 5; Зорилт 6; Зорилт 7;	Агуулгын хувьд уялдсан	Тогтвортой хөгжлийн зорилго 11;	Агуулгын хувьд уялдсан
Нийт	8		8		8		7
Нийцэн хувь	100		100		100		87.5
Тайлбар	Агуулгын хувьд уялдсан-1 Тусгагдаагүй 0 Огт хамааралгүй 0						

Хүснэгтийн үргэлжлэл

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай	Үнэлгээ	Хот байгуулалтын тухай хууль	Үнэлгээ	Ногоон хөгжлийн бодлого	Үнэлгээ
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1; 5.1.4.	Агуулгын хувьд уялдсан	4. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим 4.1.3	Агуулгын хувьд уялдсан	“Стратегийн зорилт 6”;	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1; 5.1.4.	Агуулгын хувьд уялдсан	4. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим 4.1.3	Агуулгын хувьд уялдсан	“Стратегийн зорилт 6”;	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1; 5.1.4.	Агуулгын хувьд уялдсан	4. Хот байгуулалт, төлөвлөлтийн үндсэн зарчим 4.1.3	Агуулгын хувьд уялдсан	“Стратегийн зорилт 6”;	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1.	Агуулгын хувьд уялдсан	Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.3, 7.1.8, 11.1.1, 11.5.1, 12.1, 15.1.1 дэх заалт;	Агуулгын хувьд уялдсан	“Стратегийн зорилт 6”;	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1.	Агуулгын хувьд уялдсан	Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, 11.1.2, 11.5.1, 12.2, 15.1.1 дэх заалт;	Агуулгын хувьд уялдсан	~	Тусгагдаагүй
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1.	Агуулгын хувьд уялдсан	Хот байгуулалтын тухай хуулийн 6.1.1, 6.1.3, 11.1.2, 11.5.1, 12.2, 15.1.1 дэх заалт;	Агуулгын хувьд уялдсан	“Стратегийн зорилт 6”;	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1.	Агуулгын хувьд уялдсан	Хот байгуулалтын тухай хуулийн 7.1.8, 7.1.9, 9.1.4 дэх заалт;	Агуулгын хувьд уялдсан	Стратегийн зорилт 6.	Агуулгын хувьд уялдсан
5. Хөгжлийн бодлого төлөвлөлтөд дараах зарчимийн 5.1.1; 5.1.4.	Агуулгын хувьд уялдсан	Хот байгуулалтын тухай хуулийн 3.1.18, 7.1.1, 8.1.7, 11.1.9 дэх заалт;	Агуулгын хувьд уялдсан	Стратегийн зорилт 6.	Агуулгын хувьд уялдсан
	8		8		7
	100		100		87.5
Тайлбар	Агуулгын хувьд уялдсан-1 Тусгагдаагүй 0 Огт хамааралгүй 0				

Барилга, хот байгуулалтын яам, Засгийн газрын 2016 оны 249-р тогтоолын хавсралт “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-ын 1-р хавсралтанд тусгагдсан хүснэгтийн дагуу “Хот байгуулалт, газар зохион байгуулалтын дэд салбар”-т хамаарагдах саналуудыг салбарын ерөнхий баримтлах бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлал, зарчим, зорилтод уялдаж байгаа эсэхээр дүн шинжилгээ хийхэд дийлэнх саналууд нь бодлогын баримт бичгүүдийн зорилт, зарчимтай нийцэж байна. Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүсэн хот байгуулалтын дэд салбарт хамаарах саналуудад байршил тусгагдсан эсэх мөн саналын хэрэгцээ шаардлагыг товч дурдав.

№	Хот байгуулалтын дэд салбарын санал	Байршил тусгагдсан эсэх	Тайлбар
1	Монгол орны нутаг дэвсгэрийн 55%-ийг 1:25000 масштабтай байр зүйн тоон зургаар зурагжуулах	Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Завхан, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий, Улаанбаатар	Монгол орны нутаг дэвсгэрийг бүхэлд нь бүрхсэн 1:100 000-ны масштабтай байр зүйн зургаас илүү өндөр дахин нарийвчлалтай байр зүйн тоон зургаар улс орны нутаг дэвсгэрийг зурагжуулах, дэд бүтцийн салбарын хэрэглээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн бий болгох
2	Сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээний зураглал (“Хот байгуулалтын мэдээллийн сан”-гийн суурь өгөгдлийг бүрдүүлэх)	309 сум, 21 томоохон суурин (тосгон)	Хот төлөвлөлт, хот байгуулалтын салбарт хэрэгцээтэй мэдээллийг цаг тухайд нь бүрдүүлэх чухал ач холбогдолтойгоос гадна сүүлийн жилүүдэд нилээд гарах болсон газар доорх шилэн кабель тасдах, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд газар олгох зэрэг асуудлыг цэгцлэх ажлын үндэс болно.
3	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны мониторингийн сүлжээ ажиллуулах	330 сум, 9 дүүрэг	Улсын нийт нутаг дэвсгэрийг хамарсан газрын доройтол өөрчлөлтийн нэгдсэн хяналт, мониторинг байхгүй байгаагаас хүн амын болон малын эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байна. Иймээс газрын доройтолын нэгдсэн аргаар, богино хугацаанд хяналт хийх шаардлага тулгарч байна.
4	”Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл”	Монгол Улсын хэмжээнд	Нутагшилт, суурьшлын оновчтой бодлогоор, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, соёл, ахуйн үйлчилгээ хэт төвлөрч багтаамжаасаа томорсон нийслэл хотын хүн амын бөөгнөрлийг багасгах, бүсийн тулгуур төвүүд, орон нутгийн хот суурин газрыг төлөвлөн хөгжүүлж, хүн амын хэт төвлөрлийг сааруулах, орон нутгийн хотуудын хөгжлийг бүсчилсэн хөгжлийн бодлогоор дэмжих зэрэг арга хэмжээг авах шаардлага гарч байна.
5	”Бүс нутаг, хот төлөвлөлтийн институт” ТӨҮГ-ыг байгуулах	Монгол Улсын хэмжээнд	Хот байгуулалт, зураг төслийг боловсруулах ажлыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллагууд гүйцэтгэж байгаа ч тэдгээрийн чадавхи, хүчин чадал нь улс, бүсийн чанартай, стратегийн чухал ач холбогдолтой томоохон төсөл, хөтөлбөрүүдийг гүйцэтгэхэд хүрэлцэхгүй, салбарын уялдаа холбоог хангахад мэргэжлийн байгууллага буюу институт байх зайлшгүй шаардлагатай байна.
6	”Бүсийн хөгжлийн төсөл” боловсруулах	Монгол Улсын хэмжээнд (5-6 бүсээр)	Нутагшилт, суурьшлын оновчтой бодлогоор, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, соёл, ахуйн үйлчилгээ хэт төвлөрч багтаамжаасаа томорсон нийслэл хотын хүн амын бөөгнөрлийг багасгах, бүсийн тулгуур төвүүд, орон нутгийн хот суурин газрыг төлөвлөн хөгжүүлж, хүн амын хэт төвлөрлийг сааруулах, орон нутгийн хотуудын хөгжлийг бүсчилсэн хөгжлийн бодлогоор дэмжих зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна.
7	Орхон, дархан-уул аймгийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах	Орхон, Дархан-Уул аймгийн төв	Аймгийн төв хотуудын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр нэмэлт тодотгол хийж, эдгээр хотуудын цаашдын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тодорхойлоход оршино.
8	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төслийн зураг төсөл боловсруулах	Монгол улсын хэмжээнд	Хот, суурин газрын агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг хангах, нийгмийн болон инженерийн дэд бүтэц, авто замын хүрэлцээг нэмэгдүүлэх зорилго бүхий төсөл.

Хот байгуулалтын салбарт хамаарах саналуудыг байршил тусгагдсан эсэхээр нь нягтлаж саналын хэрэгцээ шаардлагыг тусгав. Үүнээс үзэхэд саналуудын хэрэгжих байршил нь оновчтой тусгагдсан байна.

Эрчим хүчний яамнаас ирүүлсэн саналын шинжилгээ

Хүснэгт 39. Эрчим хүчний яамнаас ирүүлсэн саналын шинжилгээ

№	Эрчим хүчний салбарын санал	Байршил тусгагдсан эсэх	Тайлбар
1	Хот, суурин газрын дулаан хангамжийн чанар, хүртээмжийг сайжруулах, дулаан хангамжийн дэд бүтцийг хөгжүүлэх	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн төв болон томоохон суурин газруудад	Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн төв болон томоохон суурин газруудад дулааны станц, дулааны шугам сүлжээ барих, түлшний хангамжийг шийдвэрлэх;
2	Бүс нутгийн эрчим хүчний системийг дамжуулах чадал өндөр цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах	Чойр-Сайншанд-Замын-Үүд, Багануур дэд станцыг-УБ дэд станц, Багануур-Чойрын, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Улиастай-Дөргөн-Мянгадын, Мандалговь-Арвайхээр чиглэлүүдэд 220кВ-ын цахилгаан шугам сүлжээ, дэд станц байгуулах	Эдгээр чиглэлүүдэд 220 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлыг эхлүүлэх; Багануур дэд станцыг Улаанбаатар дэд станцтай холбох 220 кВ-ын 2 хэлхээт 118 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, дэд станцуудыг өргөтгөх ажлыг эхлүүлэх; Багануур-Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 220 кВ-ын 2 хэлхээт 518 км цахилгаан дамжуулах агаарын шугам барих, 220 кВ-ын дэд станцыг өргөтгөх ажлыг эхлүүлэх;
3	Монгол орны говийн бүсийн нар, салхины арвин нөөцөд тулгуурлан том чадлын сэргээгдэх эрчим хүчний цогцолбороос Зүүн хойд Азийн орнуудад цахилгаан экспортлох Гобитек-Азийн нэгдсэн сүлжээ санаачилгыг хэрэгжүүлэхэд бүс нутгийн орнуудтай хамтран ажиллах	-	Олон улсын банк санхүүгийн байгууллагууд, бүс нутгийн орнуудтай хамтран Гобитек-Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээний санаачилгын суурь судалгааг хийж хэрэгжүүлэх
4	Эрчим хүчний суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь хэмжээг 2020 онд 20 хувь, 2030 онд 30 хувь хүртэл нэмэгдүүлэх	Ховд гол дээр Эрдэнэбүрэнгийн 60-100 хүртэл МВт-ын усан цахилгаан станц барих ажлыг эхлүүлэх;	Эрчим хүчний нэгдсэн системийн тогтвортой ажиллагаанд нийцүүлэн сэргээгдэх эрчим хүчний /нар, салхи, ус/ хувь хэмжээг зохистой хэмжээгээр хөгжүүлэх, хэрэгжүүлэх Уур амьсгалын хөрөнгө оруулалтын сангийн бага орлоготой орнуудад сэргээгдэх эрчим хүчийг дэлгэрүүлэх хөтөлбөрийн хүрээнд сэргээгдэх эрчим хүчний төслийг хэрэгжүүлэх;

Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн саналын шинжилгээ

Хүснэгт 40. Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас ирүүлсэн саналын шинжилгээ

№	Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын санал	Байршил тусгагдсан эсэх	Тайлбар
1	Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Ховд аймгуудын нисэх онгоцны буудлуудыг ОУ-ын нисэх буудал болгон хөгжүүлэх	Дорнод, Өмнөговь, Өвөрхангай, Хөвсгөл, Увс, Ховд	Тухайн бүс нутаг бие даан гадаадын жуулчид хүлээж авах боломжийг бүрдүүлж, ОУ-ын нислэгийн үнийг бууруулах
2	Баруун бүсэд- Адал явдалт, тусгай сонирхлын, Хангайн бүсэд-Байгалийн амралт зугаалгын, Төвийн болон УБ-ын бүсэд Албан бизнесийн, Говийн бүсэд-Байгалийн палеонтологийн, Зүүн бүсэд-Түүхэн аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэх чиглэлээр аялал жуулчлалын нөөц даацын судалгаа хийж гол зорих газрууд, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хөгжлийн чиг хандлагыг бүсчлэн тодорхойлох	Эдийн засгийн бүсүүдэд	Бүс болгонд аялал жуулчлалын чиглэлээр түлхүү хөгжүүлж аялал жуулчлалын нөөц даацын судалгаа хийж гол зорих газрууд, бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, хөгжлийн чиг хандлагыг бүсчлэн тодорхойлох
3	Орхоны хөндийд “Аялал жуулчлалын үндэсний парк бий болгох”, Хөвсгөл нуурын БЦГ-т “Тогтвортой аялал жуулчлалын хөгжүүлэх”, Хэнтий аймагт “Мянгатны суут хүн их эзэн Чингис хаан” аялал жуулчлалын цогцолбор байгуулах, Дорнод аймагт “Хил орчмын аялал жуулчлалын цогцолбор байгуулах”, Өмнөговь аймагт “Палеонтологийн аялал жуулчлалын үндэсний хүрээлэн байгуулах”, Ховд аймагт “Олон ястны соёлын хүрээлэн байгуулах” болон бусад төслүүдийг хэрэгжүүлэх	Өвөрхангай, Булган, Сэлэнгэ, Дархан-Уул, Хөвсгөл, Дорнод, Хэнтий, Өмнөговь, Ховд,	Эдгээр төслүүдийг хэрэгжүүлэх замаар орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх

Зөвлөмж, санал:

Улсын хөгжлийн цогц бодлого, ойрын ирээдүйн томоохон хөтөлбөр төслүүд хэрэгжсэнээр 2020 оноос хот байгуулалтын салбарын хөгжлийн эрчимтэй өсөлттэй салбарт тооцогдох боломжтой байна. Барилга, хот байгуулалтын яамнаас ирүүлсэнээр салбарын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр МУ-ын бүтээн байгуулах өнөөгийн чадавхыг 2020 онд 1.38 дахин, 2025 онд 2.6 дахин, 2028 онд 3.9 дахин өсгөх тооцоо төсөөлөл гаргасан байна.

Хэдийгээр ийнхүү хангалттай зорилт, арга хэмжээнүүд тусгагдсан хэдий ч уг баримт бичгүүдэд тусгагдсан зорилтууд биелэгдэх боломжыг нэмэгдүүлэх, хэрэгжүүлэх арга механизм байхгүй, хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хангалтгүй, боловсон хүчний тогтолцоог бүрдүүлэх гэх мэт олон шалтгаантай холбоотой байна.

Бодлого үйл ажиллагаанд шинэчлэл хийж, газар зохион байгуулалтын удирдлага зохион байгуулалтын шинэтгэл хийх, үндэсний орон зайн мэдээлэллийн систем байгуулах, нийтийн аж ахуйн бодлого үйл ажиллагааг боловсронгуй болгох бодлогын дэд хөтөлбөр төслүүдийн батлах хэрэгжүүлэх шаардлагатай. Ингэхдээ зорилго зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагааны загвар, арга хэрэгслийн тодорхойлохын тулд менежментийн загвар, хэлхээ харилцааны схем, хэрэгжилтийг хангах эрх зүй, эдийн засаг, үйл ажиллагааны арга механизмууд зэргийг тодорхойлох шаардлагатай.

Шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийн хангалтын төлөвлөгөө гаргах, дотоод гадаад эх үүсвэрийг бүрдүүлэх, түүний зориулалт, зээллэг, өөрийн хөрөнгийн бүрдүүлэлт, барьцаа батлан даалтын арга хэрэгслүүд гэх мэт лавшруулан судлан тодорхойлох нь зүйтэй байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн байршлын зураглал болон яамдаас ирүүлсэн саналын зураглалыг хавсралтанд хавсаргав.